

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал .....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУИС	Монгол Улсын их сургууль
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

“ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ДЭЭД  
БОЛОВСРОЛ” ТӨСЛИЙН  
ЗОХИЦУУЛАГЧ Д.НАМСРАЙ ТАНАА

2020.02.19 № 06/524  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1. ОРШИЛ

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн зохицуулагч Д.Намсрай Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс 2020 оны 02 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян суварга Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

“Инженер, технологийн дээд боловсрол” төсөл нь БСШУСЯ-ны харъяанд Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын хооронд 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан MON-P11 дугаартай иений хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрээр нийт 9 жилийн хугацаанд хэрэгжихээр үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үүнд:

- Бакалаврын сургалтын хөтөлбөрийн чанарыг сайжруулах,
- Багшийн сургалт, судалгааны ажлын агуулгыг бэхжүүлэх,
- Аж үйлдвэрийн салбарт шаардлагатай мэргэшсэн ур чадвар бүхий мэргэжилтнийг сургаж бэлтгэх.

Санхүүжилтийн хувьд Япон Улсын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр болон улсын төсвийн эх үүсвэрээс санхүүждэг. Төслийн үйл ажиллагаанд зориулж нийт 7,535.00060 мянган иений хөнгөлөлттэй зээл авахаар гэрээ байгуулагдсан бөгөөд зээлийн санхүүжилтийг авахдаа 6 сараар төлөвлөж авах бөгөөд санхүүжилт авах бүрдээ суралцаж байгаа оюутнуудын нэр нэрээр ирсэн нэхэмжлэлийн төлж өмнө нь авсан санхүүжилтийн тайланг Японы Хөгжлийн Хамтын Ажиллагааны байгууллагад гарган өгч баталгаажуулдаг байна.

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн шугамаар 2015-2019 онд Япон Улсын Коосэн Үндэсний Технологийн сургуульд 113, бакалаврын хамтарсан хөтөлбөрт 107, магистрын сургалтад 31, докторын сургалтад 63, зэргийн бус сургалтад 234 нийт 548 оюутан, судлаачдыг Японы их, дээд сургуульд суралцуулахын зэрэгцээ Японы их дээд сургуульд богино хугацаанд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, инженерийн хөтөлбөр шинэчлэх, хамтарсан судалгааны ажил хийгдэж байна. Мөн Японы их, дээд сургуулиас нийт 224 зочин профессорыг урьж МУИС болон ШУТИС-д ажиллах боломжийг бүрдүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Инженер, технологийн дээд боловсрол” төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” програм хангамж ашигладаг байна.

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 29,516,014.1 мянган төгрөгөөс тооцон 295,160.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцох шаардлагагүй гэж үзсэн болно.

## 2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,725,190.8 мянган төгрөгөөр буюу 80.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,600,625.7	4,129,769.0	(1,470,856.7)
Авлага	14,988,327.5	33,205,661.5	18,217,334.0
Бараа материал	50,123.9	36,272.2	(13,851.7)
Үндсэн хөрөнгө	51,332.4	43,897.6	(7,434.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>20,690,409.5</b>	<b>37,415,600.3</b>	<b>16,725,190.8</b>
Өр төлбөр	-	-	-

Төрийн өмч	-		-
Хуримтлагдсан үр дүн	20,690,409.5	37,415,600.3	16,725,190.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>20,690,409.5</b>	<b>37,415,600.3</b>	<b>16,725,190.8</b>

Авлага дансны үлдэгдэл 18,217,334.0 мянган төгрөгөөр өссөн нь тоног төхөөрөмжийн худалдан авалтын тендерт шалгарсан Ogawa Seiki Co.,Ltd, Tec International INC, ChPM Co.,Ltd компаниудад урьдчилгаа санхүүжилт шилжүүлсэнээс шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардал дансанд 2015-2019 онуудад Японы их дээд сургуулиудад сурч байгаа 396 Монгол оюутны сургалтын төлбөрийн 28,427,611,5 мянган төгрөгийг бүртгэсэн. Энэ нь Коосэн хөтөлбөрийн 114 оюутан 3 жил, Хамтарсан бакалаврын 187 оюутан 2 жил, Докторын 64 оюутан 3 жил, Магистрийн 31 оюутан 2.5 жил тус тус Япон улсад суралцан төгсөж ирээд 5 жил Монголд ажилласны дараа тэтгэлэг болж авлага хаагдах учраас хуримтлуулан бүртгэж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь ШУТИС-д хичээллэж буй Коосэн болон Хамтарсан бакалаврын хөтөлбөрийн бэлтгэл курсын оюутнуудад ном сурах бичгийг нь олгосноос шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2015-2019 онд худалдаж авсан 4,190.0 мянган төгрөгийн аж ахуйн бараа материал, багш оюутнуудад зориулсан 31,482.1 мянган төгрөгийн ном сурах бичиг бүртгэгдэж байна.

2019 онд 6,571,957.8 мянган төгрөгийн бараа материал, тоног төхөөрөмж худалдан авч ШУТИС-ын лабораториудад хүлээлгэн өгч, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр судалгаа, сургалт хийх боломжийг бүрдүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 13,851.7 мянган төгрөгөөр буурсан.

Бараа материалын дансанд 2018-2019 оны хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 14,600.0 мянган төгрөгийн ном, гарын авлагыг ШУТИС-ын номын санд сургалтын хөтөлбөр шинчлэлийн ажил дуусаагүй шалтгаанаас шилжүүлээгүй бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 7,434.8 мянган төгрөгөөр буурсан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,108.5 мянган төгрөгөөр өссөн боловч жилийн элэгдэл байгуулснаар цэвэр дүн нь буурсан байна. Хөрөнгө оруулалтаар 4,108.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө хөрөнгийн хувьд 2015 онд 700.0 мянган төгрөгөөр Санхүүгийн тооцоолох ХХК-аас авсан санхүүгийн Accoluo програм ашиглаж байна.

Засгийн газраас оролцоо дансны үлдэгдэл 37,419,024.8 мянган төгрөг болж 16,728,615.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ өсөлт нь уг зээлийн гэрээнд заасан төсөл хөтөлбөрийн зардал бөгөөд Сургалтын зээлийн сан, төслийн нэгж, оюутнуудын хамтарсан 3 талын оролцоотой сургалтын гэрээ байгуулсаны дагуу оюутнууд сургуулиа амжилттай төгсөж ирээд 5 жил ажилласан тохиолдолд тэтгэлэг болгож зардал болгоно гэсэн тул одоогоор авлагаар бүртгэж байна.



Урьдчилж төлсөн зардал тооцоо дансны үлдэгдэл өссөн нь Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын хооронд байгуулсан гэрээний дагуу 2019 онд Япон улсад суралцаж буй оюутнуудын амьжиргааны зардал, сургалтын төлбөр, унааны зардал зэрэгт 18,217,334.0 мянган төгрөг төлснөөс шалтгаалжээ.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 3 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд улсын төсвөөс 835,000.0 мянган төгрөг, гадаад зээлийн эх үүсвэрээс 29,091,000.0 мянган төгрөгийн төсөв тус тус батлагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2019 оны гүйцэтгэлээр улсын төсвөөс 835,037.6 мянган төгрөгийн санхүүжилт авч 608,816.9 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 226,183.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Гадаад зээлийн эх үүсвэрээс 27,396,660.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн захирагч хооронд шилжиж ирсэн арилжааны банкны үлдэгдэл 5,343,583.9 мянган төгрөг, харилцах дансны хүүгийн орлого 87,407.1 мянган төгрөг, гадаад валютын ханшны зөрүүгийн олз 296,722.5 мянган төгрөгийн орлого орж, 28,907,197.9 мянган төгрөгийг зарцуулж, арилжааны банкны хүү 87,407.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2019 оны эцэст Монгол банкинд 72,679.0 мянган төгрөг, Төрийн банкинд 4,057,090.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнан харилцагч банкуудтай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

ШУТИС-иас байрны түрээсийг чөлөөлснөөс 10,629.5 мянган төгрөг, судалгааны болон сургалтын тоног төхөөрөмжийн худалдан авалтын тендерийн үйл ажиллагаа нийлүүлэлт саатсанаас 34,565.1 мянган төгрөг, зарим ажлуудын гэрээ батлагдаагүй, ажилчдын цалингийн нэмэгдэл батлагдаагүйгээс 209,977.5 мянган төгрөг, дотоод нөөц бололцоогоо ашигласан, зарим зардлын гүйцэтгэл гараагүй зэргээс 154,813.1 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4,792,699.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,784,899.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,800.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

### **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын хооронд байгуулсан гэрээний дагуу 2015-2019 онд Япон улсад суралцаж буй оюутнуудын амьжиргааны зардал, сургалтын төлбөр, унааны зардал зэрэгт төлж, урьдчилж төлсөн зардлаар бүртгэж тайлагнасан нийт 28,427,611.5 мянган төгрөгийн зарцуулалтыг үндсэн баримтаар тулган баталгаажуулах.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

“Инженер, технологийн дээд боловсрол” төсөл Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 115 мэдээллийг хугацаанд нь, 34 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-ын заалтыг дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тус төслийн 2019 оны шатахууны зарцуулалтын тооцоог шалгаж үзэхэд нийт 7,800.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулснаар тайлагнасан боловч жолоочийн тооцооны хуудас НХМаягт Т-4 маягыг хөтлөөгүй, сар бүр шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй байна.

*Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.*

##### 1.2. Эрсдэл:

Холбогдох хууль эрхийн акт зөрчигдөж, өмч хөрөнгийн тайлан тооцоонд тавих хяналт сулрах.

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан жолоочийн тооцооны хуудас НХМаягт Т-4 маягыг хөтлүүлж, тухайн сард явсан километрийг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулан нягтлан бодох бүртгэлд тусгах.

Цаашид шатахууны тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>20,639,077,106.4</b>	<b>37,375,127,263.3</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	5,600,625,718.0	4,129,769,053.4
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>5,600,625,718.0</b>	<b>4,129,769,053.4</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	257,041,808.3	-
31211	Төрийн сангийн харилцах	257,039,748.3	-
31213	Арилжааны банк дахь харилцах	2,060.0	-
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	5,343,583,909.7	4,129,769,053.4
31222	Монгол банк дахь харилцах	2,708,202,756.4	72,679,000.6
31223	Арилжааны банк дахь харилцах	2,635,381,153.3	4,057,090,052.8
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	4,781,474,530.0
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	4,781,474,530.0
3351	Байгууллагаас авах авлага		4,781,474,530.0
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	14,988,327,456.7	28,427,611,504.2
34600	Урьдчилж гарсан зардал	14,988,327,456.7	28,427,611,504.2
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	50,123,931.7	36,272,175.7
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	50,123,931.7	36,272,175.7
35410	Бичиг хэргийн материал	-	-
35420	Аж ахуйн материал	4,190,000.0	4,190,000.0
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	530,577.00	600,000.00
35470	Бусад хангамжийн материал	45,403,354.7	31,482,175.7
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>51,332,399.2</b>	<b>43,897,555.5</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>51,332,399.22</b>	<b>43,897,555.52</b>
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>50,983,454.1</b>	<b>43,584,258.6</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,126,604.8	84,496,041.5
39206	Хуримтлагдсан элэгдэл	49,584,134.5	57,332,441.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,196,430.0	42,935,521.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	22,755,446.2	26,514,862.7
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	348,945.1	313,297.0
39301	Програм хангамж	770,000.0	770,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	421,054.9	456,703.1
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>20,690,409,505.6</b>	<b>37,419,024,818.85</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>20,690,409,505.6</b>	<b>37,419,024,818.9</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>20,690,409,505.61</b>	<b>37,419,024,818.85</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>20,690,409,505.6</b>	<b>37,419,024,818.9</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	9,707,117,161.10	20,690,409,505.61
51220	Тайлант үеийн үр дүн	10,983,292,344.51	16,728,615,313.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>20,690,409,505.61</b>	<b>37,419,024,818.85</b>

#### 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>16,097,671,911.89</b>	<b>28,319,067,670.37</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,262,634,311.89</b>	<b>27,484,067,670.37</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>15,262,634,311.89</b>	<b>27,484,067,670.37</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,262,634,311.89	27,484,067,670.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,967,820.36	87,407,107.71
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	15,222,998,650.23	27,396,660,562.66
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,667,841.30	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>835,037,600.00</b>	<b>835,000,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>835,037,600.00</b>	<b>835,000,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	835,037,600.00	835,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,242,355,788.84</b>	<b>11,887,174,865.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,242,355,788.84</b>	<b>5,331,313,064.53</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,242,355,788.84</b>	<b>4,760,683,106.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>371,777,697.00</b>	<b>-</b>
210101	Үндсэн цалин	371,777,697.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,626,323.76</b>	<b>51,730,103.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,750,882.49	35,202,580.28
210202	Тэтгэмжийн даатгал	3,718,860.32	4,141,480.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,975,088.26	3,302,944.55
210204	Ажилгүйдлийн даатгал	743,772.07	825,736.14
210205	Эрүүл мэндийн даатгал	7,437,720.62	8,257,361.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,090,000.00</b>	<b>5,570,500.00</b>
210304	Байрны түрээс	6,090,000.00	5,570,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,221,961.82</b>	<b>22,358,080.59</b>
210401	Бичиг хэрэг	9,328,030.54	8,433,463.63
210402	Тээвэр, шатахуун	6,609,987.60	8,330,576.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,199.38	78,540.00
210404	Ном, хэвлэл	5,087,440.00	5,515,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,596,304.30	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>737,000.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	737,000.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>72,389,081.00</b>	<b>3,905,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	69,910,481.00	
210702	Дотоод албан томилолт	2,478,600.00	3,880,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	25,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,699,778,875.83</b>	<b>4,642,838,858.03</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,699,778,875.83	4,642,838,858.03
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,734,849.43</b>	<b>34,280,564.36</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	22,737,193.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,734,849.43	11,543,371.36
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт,</b>	<b>-</b>	<b>570,629,958.33</b>

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	шилжүүлэг		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	483,222,850.62
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		87,407,107.71
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>6,555,861,801.35</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>6,555,861,801.35</b>
222001	Тоног төхөөрөмж		6,555,861,801.35
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>10,855,316,123.05</b>	<b>16,431,892,804.49</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	1,274,283,915.24	1,591,139,672.53
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	1,274,283,915.24	1,591,139,672.53
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,146,307,693.78	1,294,417,163.78
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	547,380.57	
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,145,760,313.21	1,294,417,163.78
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	127,976,221.46	296,722,508.75
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>10,983,292,344.51</b>	<b>16,728,615,313.24</b>



### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>17,370,287,985.8</u></b>	<b><u>29,910,207,342.9</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>16,535,250,385.83</b>	<b>29,075,207,342.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	15,260,966,470.59	27,484,067,670.37
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>15,260,966,470.59</b>	<b>27,484,067,670.37</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,967,820.36	87,407,107.71
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	15,222,998,650.23	27,396,660,562.66
<b>124</b>	<b>Зээлийн орлого</b>	<b>1,274,283,915.24</b>	<b>1,591,139,672.53</b>
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр	1,274,283,915.24	1,591,139,672.53
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>835,037,600.00</b>	<b>835,000,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>835,037,600.00</b>	<b>835,000,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	835,037,600.00	835,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>12,249,603,583.8</u></b>	<b><u>19,146,103,422.8</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>12,249,603,583.8</b>	<b>19,146,103,422.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>12,249,603,583.8</b>	<b>18,575,473,464.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>371,777,697.0</b>	<b>-</b>
210101	Үндсэн цалин	371,777,697.0	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,626,323.76</b>	<b>51,730,103.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,750,882.49	35,202,580.28
210202	Тэтгэмжийн даатгал	3,718,860.32	4,141,480.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,975,088.26	3,302,944.55
210204	Ажилгүйдлийн даатгал	743,772.07	825,736.14
210205	Эрүүл мэндийн даатгал	7,437,720.62	8,257,361.56
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,090,000.00</b>	<b>5,570,500.00</b>
210304	Байрны түрээс	6,090,000.00	5,570,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,460,623.83</b>	<b>15,840,503.63</b>
210401	Бичиг хэрэг	8,789,521.45	6,658,463.63
210402	Тээвэр, шатахуун	6,950,000.00	8,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,199.38	78,540.00
210404	Ном, хэвлэл	5,087,440.00	703,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,033,463.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>737,000.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	737,000.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>72,389,081.00</b>	<b>3,905,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	69,910,481.00	
210702	Дотоод албан томилолт	2,478,600.00	3,880,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	25,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,727,522,858.20</b>	<b>18,475,690,164.62</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,727,522,858.20	18,475,690,164.62
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>-</b>	<b>22,737,193.00</b>



“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал		22,737,193.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>570,629,958.33</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	570,629,958.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	483,222,850.62
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг		87,407,107.71
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>5,120,684,402.04</u></b>	<b><u>10,764,103,920.10</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>415,213,219.91</b>	<b>10,940,543,420.91</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>415,213,219.91</b>	<b>10,940,543,420.91</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>415,213,219.91</b>	<b>10,940,543,420.91</b>
222001	Тоног төхөөрөмж	400,901,438.10	10,936,434,893.26
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,311,781.81	4,108,527.65
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(415,213,219.91)</u></b>	<b><u>(10,940,543,420.91)</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	1,145,760,313.21	1,294,417,163.78
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	1,145,760,313.21	1,294,417,163.78
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>(1,145,760,313.21)</u></b>	<b><u>(1,294,417,163.78)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>3,559,710,868.92</b>	<b>(1,470,856,664.59)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,040,914,849.06</b>	<b>4,129,769,053.39</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,600,625,717.98</b>	<b>5,600,625,717.98</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>(7,788,508,397.59)</b>	<b>(7,788,508,397.59)</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			17,495,625,558.69	<b>17,495,625,558.69</b>
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	9,707,117,161.10	<b>9,707,117,161.10</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			10,983,292,344.51	<b>10,983,292,344.51</b>
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>20,690,409,505.61</b>	<b>20,690,409,505.61</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>20,690,409,505.61</b>	<b>20,690,409,505.61</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			16,728,615,313.24	<b>16,728,615,313.24</b>
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>37,419,024,818.85</b>	<b>37,419,024,818.85</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>835,000,000.00</b>	<b>608,816,897.68</b>	<b>(226,183,102.32)</b>	<b>72.9</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>835,000,000.00</b>	<b>608,816,897.68</b>	<b>(226,183,102.32)</b>	<b>72.9</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>835,000,000.00</b>	<b>608,816,897.68</b>	<b>(226,183,102.32)</b>	<b>72.9</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-	-	
210101	Үндсэн цалин			-	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>54,619,900.00</b>	<b>51,730,103.22</b>	<b>(2,889,796.78)</b>	<b>94.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,413,300.00	35,202,580.28	(1,210,719.72)	96.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,551,700.00	4,141,480.69	(410,219.31)	91.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,641,300.00	3,302,944.55	(338,355.45)	90.7
210204	Ажилгүйдлийн даатгал	910,300.00	825,736.14	(84,563.86)	90.7
210205	Эрүүл мэндийн даатгал	9,103,300.00	8,257,361.56	(845,938.44)	90.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,200,000.00</b>	<b>5,570,500.00</b>	<b>(10,629,500.00)</b>	<b>34.4</b>
210304	Байрны түрээс	16,200,000.00	5,570,500.00	(10,629,500.00)	34.4
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,146,000.00</b>	<b>15,840,503.63</b>	<b>(17,305,496.37)</b>	<b>47.8</b>
210401	Бичиг хэрэг	11,006,000.00	6,658,463.63	(4,347,536.37)	60.5
210402	Тээвэр, шатахуун	9,960,000.00	8,400,000.00	(1,560,000.00)	84.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,660,000.00	78,540.00	(4,581,460.00)	1.7
210404	Ном, хэвлэл	6,500,000.00	703,500.00	(5,796,500.00)	10.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,020,000.00	-	(1,020,000.00)	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>54,900,000.00</b>	<b>-</b>	<b>(54,900,000.00)</b>	<b>-</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,300,000.00		(22,300,000.00)	-
210604	Урсгал засвар	32,600,000.00		(32,600,000.00)	-
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,360,000.00</b>	<b>3,905,000.00</b>	<b>(8,455,000.00)</b>	<b>31.6</b>
210701	Гадаад албан томилолт			-	
210702	Дотоод албан томилолт	12,000,000.00	3,880,000.00	(8,120,000.00)	32.3
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	360,000.00	25,000.00	(335,000.00)	6.9
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>569,774,100.00</b>	<b>509,033,597.83</b>	<b>(60,740,502.17)</b>	<b>89.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	569,774,100.00	509,033,597.83	(60,740,502.17)	89.3
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>94,000,000.00</b>	<b>22,737,193.00</b>	<b>(71,262,807.00)</b>	<b>24.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	94,000,000.00	22,737,193.00	(71,262,807.00)	24.2
	<b>ЗАРДЛЫГ</b>	<b>835,000,000.00</b>	<b>608,816,897.68</b>	<b>(226,183,102.32)</b>	<b>72.9</b>

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	<b>САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>				
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>835,000,000.00</b>	<b>608,816,897.68</b>	<b>(226,183,102.32)</b>	<b>72.9</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	835,000,000.00	608,816,897.68	(226,183,102.32)	72.9
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>12</b>	<b>12</b>	<b>-</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан			-	
620004	Гэрээт ажилтан			-	

**“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	<b>2020-02-14</b>	<b>Аудитын</b>	Санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b>	САГ-2020/702/СТА-ТХН
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	"Инженер Технологийн Дээд Боловсрол" төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит			<b>мянган төгрөгөөр</b>	

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5			9	10
1	Бараа материалын данстай холбоотой асуудал	1	Тус төслийн 2019 оны шатахууны зарцуулалтын тооцоог шалгаж үзэхэд нийт 7,800.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулснаар тайлагнасан боловч жолоочийн тооцооны хуудас НХМаягт Т-4 маягт жөтлөөгүй, сар бүр шатахууны зарцуулалтын тооцоог бодоогүй байна.	7,800.0	Зөвлөмж өгөх	2020.02.14		ИТДБТөслийн зохицуулагч ерөнхий нягтлан бодогч	Д.Намсрай Батмөнх
			<b>Дүн</b>	<b>7,800.0</b>					





